



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД А.ЦОГЦЭЦЭГ

**"ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ ХӨТӨЛБӨР- 5" ТӨСЛИЙН ХҮРЭЭНД
ЗОХИОН БАЙГУУЛАХ "НЯН СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИЙН БИОАЮУЛГҮЙ
АЖИЛЛАГАА" СЭДЭВТ СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

2017 оны 1 дүгээр сарын 18

Улаанбаатар хот

Үндэслэл:

"Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5" төсөлд цусны аюулгүй байдлыг хангах, эмнэлгийн хог хаягдлын менежмент, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, хянах чиглэлээр үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлж байна. Уг төслийн халдварын сэргийлэлт хяналтыг сайжруулах бүрэлдэхүүн хэсэг төсөлд хамрагдсан эмнэлгүүдийн бактериологи лабораторийн биоаюулгүй ажиллагааг үндэсний болон олон улсын стандартад нийцүүлэх зорилгоор лабораторийн дэд бүтцийг сайжруулах, тоног төхөөрөмжөөр хангах, ажиллагсдыг сургах үйл ажиллагаа хэрэгжүүлж байна.

Энэ хүрээнд төсөлд хамрагдсан эмнэлгийн бактериологи лабораторийн эмч, лаборант нарт 2017 оны 2 сард бактериологи лабораторийн биоаюулгүй ажиллагааны олон улсын жишиг арга зүйг олгох сургалтыг зохион байгуулж, шинжилгээний бүх үйл ажиллагаанд хүн бүр чанарыг эрхэмлэн ажиллах, биоаюулгүй ажиллагааны гарын авлага, бусад холбогдох стандарт ажиллагааны аргачлалыг шинэчлэх, улмаар биоаюулгүй ажиллагааг хангаж, шинжилгээний олон улсын жишиг арга зүйг хэрэгжүүлэх талаар тус тус мэдлэг олгохоор төлөвлөлөө.

Сургалтын зорилго:

Бактериологийн лабораторийн эмч, лаборант нар биоаюулгүй ажиллагааны олон улсын жишиг арга зүйг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхэд шинэ мэдлэг олгож, биоаюулгүй ажиллагааны зохистой хандлага, ур чадвар, дадлыг эзэмшүүлнэ.

Хамрах хүрээ:

2017 оны 2 сард төсөлд хамрагдсан эмнэлгийн бактериологи лабораторийн эмч, лаборант, ЭМЯ-ны холбогдох мэргэжилтэн, ЭМСХХ-5 төслийн менежер, зөвлөхүүд нийт 60 оролцогч

Сургалтыг зохион байгуулагч:

Эрүүл мэндийн яам, "ЭМСХХ-5" төсөл

Санхүүжүүлэгч байгууллага:

"ЭМСХХ-5" төсөл

Сургалт явуулах хугацаа:

2016 оны 2- р сарын 8-9-ны өдөр /ажлын 2 хоног /

Хүрэх үр дүн:

Төсөлд хамрагдсан эмнэлгийн бактериологийн лабораторийн эмч, лаборант нар шинжилгээний болон биоаюулгүй ажиллагааны олон улсын жишиг аргазүйг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх шинэ мэдлэг олж, биоаюулгүй ажиллагааны зохистой хандлага, ур чадвар, дадал сайжирна.

“НЯН СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИЙН БИОАЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА” сэдэвт сургалтын модуль

“Нян судлалын лабораторийг бэхжүүлэх нь” сургалт нь дотроо дараах модулийг багтаана. Үүнд:

1. Бактериологи лабораторийн биоаюулгүй ажиллагаа
 - Бактериологи лабораторийн биоаюулгүй ажиллагааны зарчим
 - Бактериологи лабораторийн биоаюулгүй ажиллагааны практикт хэрэглээ
2. Лабораторийн ажиллагсдыг биоаюулгүй ажиллагааны талаар сургах сургалт
3. Бактериологи лабораторийн биоаюулгүй ажиллагааны баримт бичиг
 - Бактериологи лабораторийн биоаюулгүй ажиллагааны гарын авлага
 - Бактериологи лабораторийн биоаюулгүй ажиллагааны хяналтын хуудас

**Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр- 5 төслийн хүрээнд зохион
байгуулах "НЯН СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИЙН БИОАЮУЛГҮЙ
АЖИЛЛАГАА" сэдэвт сургалтын хөтөлбөр**

Хугацаа	Үйл ажиллагаа	Сургалтын хэлбэр	Чиглүүлэгч багш
Эхний өдөр, 2017 оны 2 сарын 8-ны Лхагва гараг			
Сургалтын удирдагч: Л.Томалти, КОУЭМБ-ын олон улсын зөвлөх			
08.30 – 9.00	Бүртгэл		
09.00 – 9.45	Нээлтийн ажиллагаа Оролцогчдын танилцуулга		Л.Мөнхтулга, ЭМЯ –ны ЭҮТГ-ын дарга, А.Мөнхтайван, ЭМСХХ- 5 төслийн зохицуулагч Р. Эрдэнэтунгалаг, ЭМСХХ-5 төслийн менежер
09.45 – 10.00	Сургалтын өмнөх сорил	Дадлага	Т.Хосбаяр, КОУЭМБ-ын үндэсний зөвлөх
10.00 – 10.20	Цайны завсарлага		
10.20 – 12.20	Эрсдэлийн үнэлгээ	Лекц	Л.Томалти, КОУЭМБ- ын олон улсын зөвлөх Т.Хосбаяр, КОУЭМБ-ын үндэсний зөвлөх
12.20 – 13.20	Үдийн хоолны завсарлага		
13.20 – 14.20	Бактериологи лабораторийн биоаюулгүй ажиллагааны зарчим Биоаюулгүй ажиллагааны инженерийн хяналт, багаж хэрэгсэл Лабораторийн ажлын байрны аюулгүй байдлын зохион байгуулалт	Лекц	Л.Томалти, КОУЭМБ- ын олон улсын зөвлөх Т.Хосбаяр, КОУЭМБ-ын үндэсний зөвлөх
14.20 – 15.20	Лабораторийн биоаюулгүйнэ эрэглэл	Лекц	Л.Томалти, КОУЭМБ- ын олон улсын зөвлөх Т.Хосбаяр, КОУЭМБ-ын үндэсний зөвлөх
15.20-15.40	Цайны завсарлага		
15.40- 16.25	Мэргэжлийн эрүүл мэнд ба аюулгүй байдал вакцинжуулалт, HBV-ийн өртөлтийн дараах арга хэмжээ	Лекц	Л.Томалти, КОУЭМБ- ын олон улсын зөвлөх Т.Хосбаяр, КОУЭМБ-ын үндэсний зөвлөх
16.25- 17.25	Өвөрмөц эмгэгтөрөгчид (прион, бруцелл, боом гэх мэт)	Лекц	Л.Томалти, КОУЭМБ- ын олон улсын зөвлөх Т.Хосбаяр, КОУЭМБ-ын үндэсний зөвлөх
17.25-18.00	Асуулт хариулт, сургалтын эхний өдрийн дүгнэлт		Л.Томалти, КОУЭМБ- ын олон улсын зөвлөх Т.Хосбаяр, КОУЭМБ-ын үндэсний зөвлөх

2 дахь өдөр, 2017 оны 2 сарын 9-ний Пүрэв гараг**Сургалтын удирдагч: Л.Томалти, КОУЭМБ-ын олон улсын зөвлөх**

09.00- 10.00	Био-аюулгүй кабинет	Лекц	Т.Хосбаяр, КОУЭМБ-ын үндэсний зөвлөх
10.00-10.30	Био-аюулгүй байдал ба био-аюулгүй ажиллагаа Biosecurity vs Biosafety	Лекц	Л.Томалти, КОУЭМБ-ын олон улсын зөвлөх Т.Хосбаяр, КОУЭМБ-ын үндэсний зөвлөх
10.30-10.50	Цайны завсарлага		
10.50-11.50	Ариутгал, халдваргүйтгэл, устгал (багаж тоног төхөөрөмж, лабораторийн цэвэрлэгээ, автоклав)	Лекц	Л.Томалти, КОУЭМБ-ын олон улсын зөвлөх Т.Хосбаяр, КОУЭМБ-ын үндэсний зөвлөх
11.50- 12.10	Бактериологи лабораторийн биоаюулгүй ажиллагааны үнэлгээний тайлан ЭМСХХ-5 төслийн хүрээнд бактериологи лабораторийн биоаюулгүй ажиллагааг сайжруулах чиглэлд хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Лекц	Т.Хосбаяр, КОУЭМБ-ын үндэсний зөвлөх
12.10-13.10	Үдийн хоолны завсарлага		
14.00- 15.00	Бактериологи лабораторийн биоаюулгүй ажиллагааны гарын авлага	Лекц	Л.Томалти, КОУЭМБ-ын олон улсын зөвлөх Т.Хосбаяр, КОУЭМБ-ын үндэсний зөвлөх
15.00- 18.00	Биоаюулгүй ажиллагааны гарын авлага, хяналтын хуудас боловсруулах	Лекц	Л.Томалти, КОУЭМБ-ын олон улсын зөвлөх Т.Хосбаяр, КОУЭМБ-ын үндэсний зөвлөх
16.20-16.40	Цайны завсарлага		
18.00- 18.30	Сургалтын дараах мэдлэг үнэлэх сорил		Т.Хосбаяр, КОУЭМБ-ын үндэсний зөвлөх
18.30-19.00	Хаалтын ажиллагаа, Сургалтын дүгнэлт Гэрчилгээ гардуулах		Л.Томалти, КОУЭМБ-ын олон улсын зөвлөх А.Мөнхтайван, ЭМСХХ-5 төслийн зохицуулагч Р. Эрдэнэтунгалаг ЭМСХХ-5 төслийн менежер

Хянасан:






Л. Мөнхтулга /ЭҮТГ-ийн дарга/

С. Энхзаяа /ЭҮТГ-ийн мэргэжилтэн/

А. Мөнхтайван /ЭМСХХ-4,5 төслийн зохицуулагч/

Р. Эрдэнэтунгалаг /ЭМСХХ-5 төслийн бүрэлдэхүүн хариуцсан менежер/

Т. Алтанцэцэг /ЭМСХХ- 5 төслийн КОУЭМН-ийн зөвлөх багийн дэд ахлагч/



Боловсруулсан:

Т. Хосбаяр /"ЭМСХХ-5" төслийн үндэсний зөвлөх/

